# “АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭН ЖИЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт.** | | | | | | | |
| 1.1 | Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023.06.27-ны өдрийн А/41 тушаалаар баталсан “Алтанбулаг” чөлөөт бүсийн стратеги /2023-2025/ төлөвлөгөөг хэрэгжүүлэх | - | Алтанбулаг чөлөөт бүсийн стратегийн зорилтод тусгасан бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хэмжээ. | Байгууллагын 2020-2024 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан шинэчилсэн Ерөнхий төлөвлөгөө болон дэд бүтцийн ажлууд хийгдэж байна. | Чөлөөт бүсийн эрх зүй хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэж, экспортын чиглэлийн үйлдвэрлэл хөгжүүлэх, тэргүүний техник технологийг нутагшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах хэрэгжилтийг хангах журмыг үндэслэн ЭЗХЯ-ны үүрэг болгосоноор 2023-2025 оны дунд хугацааны Стратеги төлөвлөгөөний төслийг заасан хугацаанд нь боловсруулж батлуулсан. | 100 |
| 1.2 | “Алтанбулаг” чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөг боловсруулах. | - | Төлөвлөгөө боловсруулсан эсэх | “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөө, мастер төлөвлөгөө. | “Алтанбулаг” чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөө 100% боловсруулсан байна. | - Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг “Идеал групп” ХХК, “Некст степ инжинеринг” ХХК шалгарч архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу эхний болон явцын тайлан гарч ажил 80 хувьтай үргэлжилж байна. Чөлөөт бүсийн ЗАА-ны зүгээс шаардлагтай судалгааны материал, мэдээ мэдээлэл мөн газар олголт болон ААН-ийн ашиглаж буй газрын мэдээлэл мөн гадаад хамтын ажиллагаатай холбоотой судалгааны материалуудыг холбогдох нэгжүүдээс гаргуулан нэгтгэж гүйцэтгэгчид өгсөн.<br>- БХБЯ-ны ХБГХХБГазарт болон Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын Зураг төслийн хяналтын хэлтэст АБЧБүсийн Ерөнхий төлөвлөгөөний талаар нийт 4 албан бичиг төлөвлөж | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | явуулсан.<br>- Ерөнхий төлөвлөгөөний биелэлт 80%, Байр зүйн зураглал судалгааны ажил 2022 онд 100% бүрэн дууссан. | |
| 1.3 | Бодлогын баримт бичгүүд болон хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан “Чөлөөт бүсэд мөрдөх журам”-ын төсөлд санал оруулах | - | Журмын төсөл боловсруулсан эсэх | “Чөлөөт бүсэд мөрдөх” журмын төсөл, “Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх”, “Чөлөөт бүсэд тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгох“ зэрэг журмын төслүүдийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу санал авах | Журмын төсөлд оруулах саналаа холбогдох дээд байгууллагад хүргүүлэх. | 2021 оны 12 дугаар сард Чөлөөт бүсийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу “Чөлөөт бүсэд мөрдөх журам”-ын төслийг шинээр, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ дагуу Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох тухай”, “Чөлөөт бүсэд тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох тухай” журмын төслүүдийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу шаардлага хангаан “Замын-Үүд”, “Цагааннуур” чөлөөт бүсийн Ажлын албадуудтай хамтран шинээр боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн бөгөөд 2023 оны 12 сарын байдлаар журмын төслүүд батлагдаж гараагүй байна. | 80 |
| 1.4 | Бодлогын баримт бичгүүд болон хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан ОХУ- | - | Санал хүргүүлсэн эсэх | Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 онд байгуулсан “Чөлөөт бүсүүдийн хөгжлийн | Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд саналаа оруулж холбогдох байгууллагад хүргүүлэх. | - ГХЯ-ны Хөрш орнуудын газар, Гадаад худалдаа, эдийн засаг, хамтын ажиллагааны газар, Хөрөнгө оруулалт судалгааны төв зэрэг газруудтай хамтын ажиллагаатай холбоотой ажиллалаа.<br>-Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 25 дугаар хуралдаанд “Алтанбулаг” чөлөөт бүсийн зүгээс санал боловсруулж, ЭЗХЯ-нд хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тай “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай” МУ, ОХУ-тай Засгийн газар хоорондын хэлэлцээрт санал оруулах. | | | ерөнхий төлөвлөлт, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий ажлын хэсэг” нь ЭЗХЯ-ны сайдаар ахлуулан, хийгдэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө баталсан. Төлөвлөгөөнд ОХУ-тай чөлөөт бүсийн чиглэлээр гадаад хамтын ажиллагааг идэвхижүүлэ | | - ЭЗХЯ-нд ОХУ-тай “хил дамнасан чөлөөт бүс”, “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ялгамж, ижил төстэй байдлын мэдээлэл, мөн “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” байгуулах ЗГ хоорондын хэлэлцээрийн төсөл, зэргийн бэлтгэж ЭЗХЯ-нд хүргүүлсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | х, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах, чөлөөт бүсийн бараа бүтээгдэхүүний экспорт, импортын гаалийн албан татварыг бууруулах саналыг ОХУ-ын талд хүргүүлэх, чөлөөт бүсээс ОХУ-ын Хиагт боомт руу шууд холбох гарц байгуулах зэрэг саналаа ЭЗХЯ-нд уламжилсан. | | | |
| 1.5 | Чөлөөт бүсийг олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх санал боловсруулах. | - | Санал боловсруулсан эсэх | 2023 онд шинээр хийгдэх ажил | WFZO-ын гишүүн Чөлөөт бүсүүдийн хөгжлийн амжилттай туршлагуудын талаар судалгаа хийгдэж, | - Дэлхийн чөлөөт бүсийн байгууллага болох / WFZO/ -н талаар судалгаа хийж мэдээллийн сан үүсгэсэн.<br>Судалгааг дараахь чиглэлээр гаргасан Үүнд ;<br>1. Дэлхийн чөлөөт бүсийн байгууллага /WFZO/-ын зорилго юунд чиглэсэн талаар<br>2. WFZO /Дэлхийн чөлөөт бүсийн байгууллага/ үүссэн түүх<br>3. Үндсэн зорилтууд<br>4. Дэлхийн чөлөөт бүсийн байгууллагад гишүүнчлэлд элсэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийн сан бүрдсэн байна. | давуу талууд гэсэн чиглэлээр судалгаа хийгдсэн. | |
| 1.6 | Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах. | - | Хамтын ажиллагаа эхлүүлсэн ААН-ийн тоо | 2022 онд хамтран хэрэгжүүлсэн төсөл ба 2023 онд үргэлжлэн хийгдэх ажил. | KEXIM, KOTRA зэрэг байгууллагуудаар дамжуулан чөлөөт бүсэд хөрөнгө оруулах сонирхолтой БНСУ-ын компаниудтай холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлсэн байна. | - Монгол Улс нь тээвэр логистикийн дэд бүтцийг хөгжүүлэхийн тулд хөгжлийн урт хугацааны бодлого болох “Алсын хараа-2050”, дөрвөн жилийн хөгжлийн төлөвлөгөө (2020-2024) зэрэг төрийн бодлогын баримт бичигт логистикийн төв байгуулахтай холбоотой зүйлийг тусгасан. Түүнчлэн Алтанбулаг (ОХУ-ын нутаг дэвсгэртэй хиллэх хэсэг), чөлөөт бүсэд логистикийн төв байгуулж эдийн засгийн сэргэлтэд хувь нэмэр оруулах зорилготой юм. Монголын улсын засгийн газар, логистикийн дэд бүтцийн эрэлт хэрэгцээг харгалзан Kotra, KSP-ээс зөвлөх үйлчилгээ авч Алтанбулаг тээвэр, логистикийн төвийг барих ТЭЗҮ хийж дуусгаж ЗТХЯ-д хүлээлгэн өгсөн.<br>ESCAP- Ази Номхон далайн нийгэм эдийн засгийн комиссд дулааны станц, тээвэр логистикийн төв зэрэг ажлуудад хөрөнгө босгуулахаар төслийн мэдээлэлээ шинэчилж явуулсан.<br>Чөлөөт бүс рүү 25 км төмөр зам тавих талаар ажлын хэсэг байгуулагдаж 2023 оны 12/3-аас 2023 оны 12/06-ний өдөр хүртэл Сэлэнгэ аймагт ажиллаж судалгаа хийсэн. Судалгааны үр дүнд төмөр замын зураг төслийг хийлгэх шийдвэрт хүрсэн.<br>ОХУ-ын” НПП Старлинк” компаниас чөлөөт бүсэд газар эзэмшиж шилэн кабель үйлдвэрлэх хүсэлтээ ирүүлэн компанийн захирал өөрийн биеэр ирж хамтарсан уулзалт хийсэн.<br>МУ-д мөрдөгдөж байгаа стандартын дагуу Агуулахын аж ахуйд тавигдах шаардлагыг боловсруулсан. | 100 |
| 1.7 | Гадаад, дотоодын хөрөнгө оруулагч ААН, байгууллагуудтай холбоо тогтоох, хамтран ажиллах. | - | Байгууллагын хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн тоо | - Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийг байгуулах. | ОХУ-ын Эрхүү мужийн “Корпорация развития” ХК-ийн ерөнхий захирал Эрхүү мужийн “Корпорация развития” ХК-ийн ерөнхий захирал А.Ю.Лаутин болон бусад албаны хүмүүсийг “Алтанбулаг” чөлөөт бүсийн ЗАА хүлээн авч, тус уулзалтаар хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх, Эрхүү мужийн аялал жуулчлалын “Байкальск” бүстэй харилцаа тогтоох, туршлага судлах, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын тал дээр хамтран ажиллахаар санал солилцсон.<br>- БНХАУ-ын Шэнжин худалдааны чөлөөт бүс болон Эрээн хотын хилийн худалдааны бүсэд хамтын ажиллагаа өргөжүүлэх хүрээнд туршлага судлах арга хэмжээг зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 24-р хуралдааны хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлсэн.<br>- Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник соёлын хамтын ажиллагааны Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын комиссын ээлжит 8 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, IX хуралдаануудын протоколд санал бэлтгэн хүргүүлсэн<br>-2022 оны ОХУ-ын | | байгуулах, хамтын ажиллагааны "Хамтран ажиллах санамж бичиг"-байгуулах тухайд хамтран ажилласан.<br>Эдийн засгийн хөгжлийн яамны зүгээс энэ удаагийн туршлага судлах арга хэмжээг тодорхойгүй хугацаагаар түр хойшлуулаад байна.<br>-НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Зүүн болон Зүүн Хойд Азийн салбар /ESCAP/-ын Ази, Номхон далайн бүс нутгийн дэд бүтцийн санхүүжилт ба төр, хувийн хэвшлийн түншлэлийн сүлжээний "Алтанбулаг" чөлөөт бүс дээр хийгдэх боломжтой төслүүдийн мэдээллийн орчуулгыг хийж холбогдох хэлтэст өгсөн.<br>-"Алтанбулаг" чөлөөт бүс болон "Алтанбулаг чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчдын хөгжлийн бүс зөвлөл" ТББ хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.<br>-ХХЕГ-тай "Хамтран ажиллах" гэрээнд нэмэлт өөрчлөлтөд тусгах саналын төслийг боловсруулан хүргүүлж гэрээг байгуулсан.<br>- Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 25 дугаар хуралдаан, Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын 16 дугаар хуралдааны хүрээнд ОХУ-ын Аж үйлдвэр, худалдааны яамны Олон улсын хамтын ажиллагаа, гадаад худалдааны тусгай зөвшөөрлийн газрын дарга Р.А. Чекушовын 2023 оны 10-р сарын 11-ны өдрийн "Алтанбулаг" чөлөөт бүсэд хийх Ажлын айлчлалтай холбогдуулан тус бүсийн тухай шинэ танилцуулга, хөтөлбөр, протокол, уулзалтын орчуулга хоёр хэл дээр тус бүр хийгдсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | БНБуриад Улсын “Экспортыг дэмжих төв”-тэй “Хамтран ажиллах тухай” санамж бичиг байгуулсан. - Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны IX хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг боловсруулан хүргүүлсэн. | | | |
| 1.8 | Төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах, гадаад дотоодод зохиогдож буй бизнес-форум, үзэсгэлэн яармагт оролцох ажлыг зохион байгуулах. | - | Оролцсон арга хэмжээний тоо /2-оос доошгүй арга хэмжээ/ | Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний дагуу ажилласан. Олон улсын үзэсгэлэн худалдаа | Хурал, зөвлөгөөн, бизнес-форум, үзэсгэлэн яармагт оролцсон тухай үр дүнг тайлагнаж, түүний мөрөөр тодорхой ажлуудыг | ОХУ-ын БНБуриад Улсын “Экспортыг дэмжих төв”, “Бүс нутгийн хөгжлийн сан”-тай тогтмол холбоотой ажиллаж байна.<br>--37-р “Ворота в Азию” олон улсын яармаг үзэсгэлэн дээр Эрхүү мужийн байгаль орчин, хүнсний бүтээгдэхүүн, аялал жуулчлалын чиглэлийн аж ахуйн нэгжүүдтэй хамтарсан уулзалт хийж санал бодлоо солилцсон.<br>--МҮХАҮТ, Дорнод Сибирийн ХАҮТ “Монгол-Оросын бизнес форум”—д оролцож Эрхүү мужийн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, хүнсний чиглэлийн мөн Монголын бизнес эрхлэгч нартай чөлөөт бүсийн үйл ажиллагааны тухай танилцуулж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулахад төрийн албаны төв байгууллагу удтай хамтран ажиллах, хөрөнгө оруулагчдын хамтарсан уулзалт зохион байгуулах, Олон улсын байгууллагу удтай мэдээлэл солилцон хамтран ажиллах хүсэлт хүргүүлсэн. | гүйцэтгэх. | санал бодлоо солилцсон<br>- Монгол, Орос, Хятадын ХАҮТ-уудын Худалдаа, эдийн засгийн 16-р форумын “Чөлөөт бүсийн тухай” салбар хуралдаанд оролцож, гадаад дотоодын байгууллагуудад чөлөөт бүсийн тухай мэдээлэл болон орчуулга хийгдсэн.<br>- ОХУ-ын “Корпорация развития” ХК-тай холбоотой ажиллаж байна.<br>-Монгол Улсын “Үрсэлгээ центр” ХХК, “Хушхан” ХХК, “Монгэйт” ХХК, “Монголын ногоон хэрэм” хөгжлийн төв, “Болд” ХХК-тай чөлөөт бүсийн үйл ажиллагаа, татвар, эрх зүйн орчны тухай мэдээлэл хүргүүлсэн.<br>-ОХУ-ын Эрхүү мужийн “Енисей”, “Усолье” эмчилгээ сувилалын төв, зөгийн балны “Пасека Галеева” ХХК, “Центр кирпича” ХХК, “Россия и Монголия” сэтгүүлд бүсийн тухай сурталчилан таниулсан.<br>-ОХУ-ын Аж үйлдвэрийн паркийн ассоциаци-ийн хүсэлтийн дагуу ОХУ-ын “Старлинк” ООО-ийн ерөнхий захирал А.А. Киянов-тай уулзалт хийж, санал бодол солилцов.<br>-ОХУ-ын Эрхүү мужийн “Иркутская нефтяная компания” ХХК-ийн Хуулийн газрын дарга А.Баширов болон бусад албаны хүмүүсийг “Алтанбулаг” чөлөөт бүсийн ЗАА-нд хүлээн авч тус уулзалтаар газрын тос, байгалийн хий, полимерын гэх мэт химийн үйлдвэрлэл чөлөөт бүс дээр байрших асуудлаар мөн цаашдаа харилцаатай байх, туршлага судлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын тал дээр хамтран ажиллахаар санал солилцсон./мэдээлэл, танилцуулга хийгдсэн/<br>-ОХУ-БНСУ-ын хамтарсан “GEO” группын захирал Очиров Бато “Алтанбулаг” чөлөөт бүс дээр гурилын үйлдвэр, тээрэм, үр тарианы боловсруулалтын үйлдвэрлэл барих талаар санал бодол, мэдээлэл солилцсон. /мэдээлэл, танилцуулга хийгдсэн/<br>-ТЕГ-н татварын удирдлага, хамтын ажиллагааны газартай хамтран ажилласан. Үүнд: Чөлөөт бүс – “ЧБ архи дарс” гэсэн акц бэлэн<br>-ТЕГ-ын Татварын нэгдсэн систем шинэчлэл хийгдсэн./ЧБ-н | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгө оруулагч нартай сургалт зохион байгуулсны дараа бүртгэлийн системд холбогдоно/<br>-ЧБ барааны үлдэгдлийг авч, барааны тэмдэгтийг олгох<br>-Эхлээд татваргүй барааны дэлгүүрүүдэд сургалт хийгдээд дараа нь чөлөөт бүсүүдэд сургалтыг хийхээр төлөвлөж байна.<br>- ГЕГ-т чөлөөт бүс дэх гаалийн хяналт тавих үйл ажиллагааг гаалийн бүртгэлжүүлэлтийн системд бүрэн холбох, хяналт тавих, цогц шийдлийг олж, зохицуулалтын арга хэмжээ авч хамтран ажиллах тухай албан хүсэлтийг 3 удаа хүргүүлсэн.<br>-Гаалийн Ерөнхий газрын Мэдээлэл технологийн газартай Гаалийн CAIS системд холбогдох, систесийн тохируулга хийх талаар 3 удаа уулзалт хийсэн.<br>-Монгол Улсын Шадар сайдын ивээл дор зохион байгуулагдсан "Эрсдэлийн эсрэг форум-2023"-д байгууллагын ажилтнуудыг хамруулах ажлыг зохион байгуулсан . | |
| **Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| 2.1 | Чөлөөт бүсэд шинээр газар эзэмших эрх авсан аж ахуйн нэгжүүдийн хувийн хэргийг бүрдүүлэх, үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд тогтмол хяналт тавьж холбогдох судалгааг цаг тухай бүр гарган ажиллах. | 1,617, 500 төгрөг /Улсын маягт хэвлүүлэх зардал/ | Шинэчилсэн бүртгэл хийсэн эсэх | 2022 оны байдлаар Чөлөөт бүсэд бүртгэлтэй нийт 139 ААН байна. | Бүсэд үйл ажиллагаа эрхлэх ААН бүр журмын дагуу хуулийн этгээдийн бүртгэлд хамрагдаж, хувийн хэргийг бүрдүүлэх. | 2023 оны байдлаар "Алтанбулаг" чөлөөт бүсэд нийт 144 аж ахуйн нэгжийн 154 нэгж талбарын хувийн хэргийг бүрдүүлэн хавтасжуулах, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд тогтмол хяналт тавьж холбогдох судалгааг цаг тухай бүрд гаргаж ажиллаж байна.<br>Үйл ажиллагаа явуулж байгаа 34 ААНБ-уудын бүрэн камержсан байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан. 34 ААНБ-уудаас 22 нь тусдаа агуулахтай, 11 агуулах нь бүрэн камержсан байна. | 100 |
| 2.2 | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах эсэх шийдвэр гаргах | | Тусгай зөвшөөрөлтэй холбоотой шийдвэр гаргасан эсэх | 2022 оны байдлаар<br>- Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй-24 ААН,<br>- Тамхи | ААН-д тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх тухай шийдвэрийг гаргана. | 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Зөвшөөрлийн тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-тай уялдуулан Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 62 дугаар тушаалаар батлагдсан "Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, "Чөлөөт бүсэд тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгох журам"-ыг тус тус шинэчлэх, журмын төсөл шинээр боловсруулах ажил | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | худалдах тусгай зөвшөөрөлтэй-21 ААН,<br>- Эмийн сан-1,<br>- Эм ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй-1 ААН байна. | | хийгдэж байгаатай холбогдуулан 2023 оны 12 дугаар сарын байдлаар чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрлийг шинээр олгоогүй.<br>- Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй-24 ААН,<br>- Тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй-21 ААН,<br>- Эмийн сан-1,<br>- Эм ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй-1 ААН байна.<br>2023 онд согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн сунгалт-11<br>- Тамхи худалдах тусгай зөвшөөрлийн сунгалт-5 тус тус хийгдсэн байна. | |
| **Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 3.1 | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | Ажил олгогчоос олгох 1 удаагийн тэтгэмж, урамшуулал | Зэрэг дэв олгох, цалингийн шатлал нэмэгдүүлэх, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, мэргэшлийн зэргийн цол, ур чадварын нэмэгдэл олгох, шагнах, урамшуулах, нөхөх төлбөр, тусламж олгох захирамж гаргасан эсэх | 2017-2022 он хүртэл Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн. | Төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх. | - 2023.01.11-ний Б/01 тоот захирамжаар төрийн захиргааны албан хаагчдын цалингийн хэмжээ, Б/02 тоот захирамжаар төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн хэмжээ, Б/03 тоот захирамжаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай, 2023.01.16-ны Б/04 тоот захирамжаар албан хаагчдын нийт цалин хөлс болон нэмэгдлийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоосон.<br>- 2023.01.11-ний Б/04 тоот, 2022.02.16-ны Б/17 тоот тус тус захирамжаар жирэмсэн 2 албан хаагчийн эрүүл мэндийн шалтгааныг харгалзан 1-2 сар зайнаас ажиллах зөвшөөрөл олгосон.<br>- 2023.02.10-ны Б/14 тоот захирамжаар Цагаан сарын баярыг тохиолдуулан байгууллагаас тэтгэвэрт гарсан 3 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн.<br>- 2023.02.16-ны Б/16 тоот захирамжаар ээлжийн амралтын хуваарийг баталж оны эцсийн байдлаар нийт албан хаагч ээлжийн амралтаа биеэр эдэлсэн.<br>- 2023.04.14-ний Б/34 тоот, 2023.05.05-ны Б/37 тоот тус тус захирамжаар гэр бүлийн гишүүн нь нас барсан 2 албан хаагчид 200,00-350,000 төгрөгийн тусламж үзүүлсэн.<br>- 2023.11.16-ны өдрийн Б/75 тоот захирамжаар 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн албан хаагчдын өдрийн хоолны зардлыг 13500 төгрөгөөс 30000 төгрөг болгон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдүүлсэн.<br>- Өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагчид тус бүр 150,000 төгрөгийн үнэ бүхий зүйл гардуулсан.<br>- Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 102 жилийн ойн баяр, Эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний түүхт 100, 101 жилийн ойн баяр, жил бүрийн наймдугаар сард тэмдэглэн өнгөрүүлдэг "Эрчим хүчний ажилтны өдөр"-ийг тус тус тохиолдуулан хамт олноо манлайлан ажилласан дараах албан хаагчдыг шагнуулахаар нэр дэвшүүлж холбогдох материалыг ЭЗХЯ, ЭХЯ-д хүргүүлсний дагуу дараах албан хаагчид шагнагдсан. Үүнд:<br>Төрийн дээд "Алтангадас" одонгоор ХБХОХ-ийн мэргэжилтэн Н.Димаа;<br>ЭЗХЯ-ны "Эдийн засгийн тэргүүний ажилтан" хүндэт тэмдэгээр Бүртгэл, санхүүгийн хэлтсийн дарга Б.Зоригоо,<br>Аж ахуйн үйлчилгээ, ашиглалтын тасгийн дарга Р.Өлзийбаатар,<br>Ерөнхий нягтлан бодогч Э.Эрдэнэтуяа,<br>ГХХАМТХ-ийн мэргэжилтэн Ц.Аззаяа,<br>мэргэжилтэн Х.Зоригт,<br>ДБХГХХ-ийн мэргэжилтэн Г.Гантулга,<br>Архив, бичиг хэргийн ажилтан Б.Сарнай;<br>"Эрчим хүчний тэргүүний ажилтан" тэмдэгээр ДБХГХХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Баярсайхан;<br>Эдийн засаг, хөгжлийн яамны "Жуух бичиг"-ээр ГЭЗХНХ-ийн ахлах мэргэжилтэн М.Занданжав,<br>ДБХГХХ-ийн мэргэжилтэн Ж.Мэргэнбаатар, Ж.Нарангэрэл;<br>2023 оны 12 сард болсон Санхүү, бүртгэлийн ажилтны өдрөөр Сангийн яамны "Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан цол, тэмдгээр БСХ-ийн Тооцооны нягтлан бодогч Ө.Содов<br>Сангийн яамны Санхүү, бүртгэлийн тэргүүний ажилтан цол, тэмдгээр БСХ-ийн Эдийн засгийн тооцоо, судалгаа хариуцсан мэргэжилтэн Ц.Пунцагбалжир | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сангийн сайдын Жуух бичгээр БСХ-ийн Нярав О.Энхмаа нар тус тус шагнагдсан байна.<br>- 2023.07.07-ны Б/46 тоот, 2023.08.17-ны өдрийн Б/53 тоот тус тус захирамжаар 2 албан хаагчид шинэ төрсөн хүүхдээ асрах цалинтай чөлөөг олгосон.<br>- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоол, Эдийн Засаг Хөгжлийн сайдын 2023.07.07-ны өдрийн А/50 дугаар тушаал тус тус гарсны дагуу 2023.08.21-ний өдрийн Б/55 тоот захирамжаар албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон.<br>- 2023.08.10-ны Б/51 тоот захирамжаар өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн Цэрэндорж овогтой Бужидмаад төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 4,219,950 (дөрвөн сая хоёр зуун арван есөн мянга есөн зуун тавин) төгрөг, Гэрэлчулуун овогтой Тамирт 16,200,740 (арван зургаан сая хоёр зуун мянга долоон зуун дөчин) төгрөгийг тус тус олгосон.<br>- Нийт албан хаагчдын 2023 оны 1-р улирал, хагас жил, 3-р улирлын тус тус ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн захирамжаар улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг үндсэн цалингийн 35-40 хувиар тооцож олгосон. | |
| 3.2 | Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хичээл, үйлдвэрлэлийн зардал | Сургалтад хамруулсан эсэх | 2022 онд давхардсан тоогоор 29 албан хаагчийг богино болон дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан. | Хөтөлбөр боловсруулж хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийг зохих сургалтад хамруулж үр дүнг тооцсон байна. | 2023 онд Удирдлагын академиас улсын төсвийн санхүүжилтээр сургах сургалтын хөтөлбөрийн дагуу<br>- “Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”-д Захирагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Уламбаяр,<br>- “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”-д Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ц.Аззаяа,<br>- Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад Бүртгэл хариуцсан мэргэжилтэн Г.Гансүх,<br>- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Нарангэрэл, Бүртгэл хариуцсан мэргэжилтэн Э.Номундарь нарыг хамруулахаар тодорхойлсны дагуу албан хаагчид | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтад хамрагдсан.<br>- ДБХГХХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дулааны хангамж хариуцсан мэргэжилтэн Г.Баярсайханыг 2023.10.03-2023.10.27-ны өдрүүдэд “Эрчим хүчний салбарын дулааны инженерүүдэд мэргэшсэн инженерийн зэрэг олгох сургалт”-д хамруулсан.<br>- Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүйн сургалтад нийт албан хаагчид 7 хоног бүрийн Пүрэв гаригт тогтмол хамрагдаж байна. | |
| 3.3 | Хүний нөөцийн систем hr.csc.gov.mn сайтад хүний нөөцийн мэдээллийг тогтмол оруулах. Хуулийн үйлчлэлд хамаарах албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах meduuleg.iaac.mn сайтад оруулах, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах | - | Хүний нөөцийн системийн мэдээлэл.<br><br>ХОМ, ХАСУМ. | Хүний нөөцийн системд албан хаагчдын мэдээллийг бүрэн оруулсан. Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлсэн. | meduuleg.iaac.mn, hr.csc.gov.mn сайтад албан хаагчдын мэдээллийг оруулах, мэдээ тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх. | 2023 онд Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд /hrm.csc.gov.mn/ байгууллага болон албан хаагчдын ажлын түүхийг үүсгэж, хувийн, боловсролын, туршлагын, албан тушаалын, цалингийн мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулж байна.<br>2022 оны шинэчилсэн ХАСХОМ гаргах 25 албан хаагчийн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гарган баталгаажуулж, холбогдох тайлангын хамт дээд шатны эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.<br>2023 оны 12 сарын байдлаар нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн болон үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн нийт 17 нэр дэвшигчийн ХАСУМ болон албан тушаалын тодорхойлолтын хамт АТГ-т хянуулахаар хүргүүлснийг хуульд заасан үндэслэлийн дагуу хянан үзээд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх нөхцөл байдал тогтоогдоогүй 17 нэр дэвшигчийг тухайн сул орон тоо болон чиг үүрэг өөрчлөгдсөн албан тушаалд тус тус томилж Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу томилогдсоноос хойш 30 хоногийн хугацаанд хувийн ашиг сонирхлыг мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлгийн системд баталгаажуулан ажиллаж байна. | 100 |
| 3.4 | Албан тушаалын сул орон тоог нөхөх, Төрийн албан хаагчийн хувийн | - | Байгууллагын сул орон тоог нөхөх | 2023 онд шинээр хийгдэх ажил | Байгууллагын сул орон тооны захиалга өгсөн байх. Албан | 2023.01.24-ний 01/21 дугаар албан тоотоор ТАЗ-ийн Эдийн засаг, хөгжлийн яамны салбар зөвлөлд нийт 9 албан тушаалын сул орон тооны захиалгыг хүргүүлсэн. Үүний дагуу албан тушаалын тусгай шалгалтын бүртгэл 2023.02.27-28-ны | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэргийг бүрдүүлэх, шинэчлэх. | | захиалга, Төрийн албан хаагчийн хувийн хэрэг. | | хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангасан байх. | өдрүүдэд явагдаж, 2023.03.10-ны өдөр шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтын үр дүнд:<br>• Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 04 дугаар нэр дэвшүүлэх тухай тогтоол гарсан;<br>• 5 албан тушаалын тусгай шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн захиргааны албан хаагчаар жинхлэн томилсон /Эдийн засгийн тооцоо судалгаа хариуцсан мэргэжилтэн Ш.Пунцагбалжир, Дулааны хангамж хариуцсан мэргэжилтэн Г.Баярсайхан, Усан хангамж хариуцсан мэргэжилтэн О.Сувдаа, Бүртгэл хариуцсан мэргэжилтэн Э.Номундарь, Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /Хятад хэлтэй/-ий Г.Байгаль/<br>• Дээрх албан хаагчид 2023.04.14-ний өдөр “Монгол Улсын Төрийн Захиргааны албан хаагчийн тангараг” өргөсөн.<br>• 2 албан тушаалын тусгай шалгалт тодорхойгүй хугацаагаар хойшилсон /ЗАА-ны дарга, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга/ ;<br>• Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /Англи хэлтэй/, Гэрээ эрх зүй хариуцсан мэргэжилтний тусгай шалгалтад тус тус 1, 1 иргэн бүртгүүлсэн боловч шалгалтад ороогүй.<br>- ТАЗ-ийн Эдийн засаг, хөгжлийн яамны салбар зөвлөлийн 2023.04.06-ны өдрийн 08 дугаар тогтоолоор тус яам болон яамны харъяалалд хамаарах төрийн байгууллагуудын сул орон тооны мэдээллийг байршуулах, цаашид төрийн байгууллага хооронд албан хаагчдыг шилжин ажиллах боломжийг хангах /mrd.gov.mn цахим хуудсанд/ ажлын хүрээнд 2023.04.10-ны өдрийн 01/177 албан тоотоор байгууллагын сул орон тооны мэдээллийг, 2023.07.25-ны өдөр байгууллагын 11 сул орон тооны захиалгыг тус тус хүргүүлсэн. Гэвч өнөөдрийг хүртэл яамны салбар зөвлөлөөс манай байгууллагын бүтцийг шинэчлэх ажил явагдаж байгаа бөгөөд уг ажлыг дууссаны дараа сул орон тоог нөхөх ажлыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулах тул шалгалтыг тодорхойгүй хугацаагаар зарлахгүй гэсэн хариуг өгөөд байна.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 126 дугаар тогтоолын дагуу “Алтанбулаг” чөлөөт бүсийн ЗАА нийт 42 орон тоотой бөгөөд 2023.12.05-ны өдрийн байдлаар 27 албан хаагч ажиллаж, 4 албан хаагч хүүхэд асрах түр чөлөөтэй, 1 албан хаагч амаржсаны амралттай, 12 албан тушаалын орон тоо сул, 7 албан хаагч албан үүргийнхээ зэрэгцээ сул орон тоог түр орлон гүйцэтгэн ажиллаж байна. | |
| 3.5 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан гаргах, архив, албан хэрэг хөтлөлтийг журмын дагуу явуулах. | - | Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, албан хаагч, нэгж тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан. Архив, албан хэрэг хөтлөлтийн бүртгэл. | Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг гаргасан. 2022 онд байгууллагад Ирсэн албан бичиг-437, явуулсан албан бичиг-455, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 85 захирамж, хүний нөөцийн чиглэлээр 81 захирамж гарсан. | Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, албан хаагч, нэгж тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан баталгаажсан байна. Архив, албан хэрэг хөтлөлт журмын дагуу бүртгэл хийгдсэн байх. | Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж 2023.01.24-ний 01/22 албан тоотоор ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн Засаг, Хөгжлийн сайд 2023.07.05-ны өдөр Алтанбулаг чөлөөт бүсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянан баталгаажуулсан.<br>2023 онд байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 51 захирамж, хүний нөөцийн чиглэлээр 76 захирамж тус тус гарч хугацаанд нь шийдвэрлэсэн.<br>Ирсэн албан бичиг-289, явуулсан албан бичиг-323. Хариу өгч шийдвэрлэх шаардлагатай албан бичгүүдийг шийдвэрлэгдэхэд нь хяналт тавьж ажиллаж байна. Үүнээс:<br>➢ Хариутай, шийдвэрлэх албан бичиг - 180<br>❖ Хугацаандаа шийдэвэрлэгдсэн - 172<br>❖ Хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн - 0<br>❖ Хугацаа болоогүй шийдвэрлэгдээгүй – 8<br>❖ Хугацаа хэтэрсэн шийдвэрлэгдээгүй – 0<br>- 2003-2019 он хүртэлх устгах хэргийн актыг байгууллагын БНШК-ын хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлаар хэлэлцүүлж, Үндэсний төв архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар оруулж хэлэлцүүлсэн боловч байгууллагын данс бүртгэл баталгаажаагүй учир буцаагдсан.<br>- Байгууллагын данс бүртгэлийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баталгаажуулахын тулд 2003-2022 оны Алтанбулаг чөлөөт бүсийн архивт хадгалагдаж буй байнга, түр, 70 жил хадгалах баримтуудын бүртгэлд нөхөн бүрдүүлэлт хийж, тухайн баримт бичгүүдэд нэг бүрчлэн эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийж нягтлан шалгах ажлыг БНШК ажиллаж хууль, дүрэм, журам, стандартын дагуу тухай бүр хийж гүйцэтгэж дараах ажлуудыг хийж байна. Үүнд:<br>- - 2003-2022 он хүртэлх байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл дэх зарим баримтуудад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт, нягтлан шалгалт хийж бүртгэлийг шинэчлэх.<br>- 2003-2007 он хүртэлх 70 жил хадгалах хадгаламжийн нэгжүүдээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцооны хуудас хамт үдэгдсэн байсныг тус тусад нь хадгаламжийн нэгж болгон эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийж, байнга хадгалах хадгаламжийн нэгж болон 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд оруулж, шинэчлэн бүртгэлжүүлэх.<br>- 2003-2007 он хүртэлх цалингийн цэсэд цагийн бүртгэл, ээлжийн амралтын мэдэгдэл болон цагийн бүртгэл, ажилд томилсон тушаал зэрэг баримтууд хамт үдэгдсэн байсныг нягтлан шалгаж, эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийж тус тусад нь хадгаламжийн нэгж болгон архивлах ажлыг хийж гүйцэтгэн 70 жил хадгалах хадгаламжийн нэгж болон түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд оруулж, шинэчлэн бүртгэлжүүлэх. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Архивт хадгалагдаж буй баримт бичгүүдээс Захирагчийн ажлын албаны албан хаагчдад шаардлагатай баримтуудыг хувилж, ашиглуулах ажлыг тухай бүр хурдан шуурхай гаргаж өгч, ашиглуулах ажлыг гүйцэтгэж, баримт ашиглалтын бүртгэл хөтөлж байна.<br>- 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу холбогдох баримтуудыг байгууллагын архивт хүлээн авсан.<br>- 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг БНШК-ын хурлаар хэлэлцэж, баталсан. | |
| 3.6 | Санхүүгийн тайлан балансыг хугацаанд нь гаргаж, холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэх, аудитын байгууллагаар баталгаажуулж, сангийн яамны программд оруулах. | 1.9 сая төгрөг /Аудит баталгаажуулалтын зардал/ | Санхүүгийн болон аудитын тайланг хүргүүлсэн эсэх | Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж харъяа дээд байгууллагад хүргүүлж, аудитын байгууллагаар баталгаажуулсан. 4.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй. | Хагас, бүтэн жилийн тайланг баталгаажуулан гаргаж холбогдох байгууллад хууль журмын хугацаанд хүргүүлэн ажиллах. | “Алтанбулаг” чөлөөт бүсийн санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд нь гаргаж, холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэн, аудитын байгууллагаар баталгаажуулж, хуулийн хугацаанд тайланг хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| 3.7 | Ирэх 2024 оны төсвийн төсөөллийг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж дээд шатны байгууллагад танилцуулах, батлагдсан хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | - | 2024 оны төсөв, төсвийн төсөөллийг боловсруулсан эсэх | Чөлөөт бүсийн 2022 оны төсөв, 2023-2024 оны төсвийн төсөөлөл боловсруулан дээд шатны байгууллагад хүргүүлсэн. | Чөлөөт бүсийн 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх. | Чөлөөт бүсийн 2024 оны үйл ажиллагааны төсөв болон 2024-2025 оны төсвийн төсөөлөл боловсруулж, ЭЗХЯамнд хүргүүлсэн. Төсвийн тодруулгыг 4 удаа хийж 3 удаа албан бичгээр хүргүүлэн ажилласан. 2023 оны 04 дүгээр сарын 05 ны өдрийн 01/170, 01/171 тоот албан бичиг, 08 дугаар сарын 09-ны өдрийн 01/240 тоот албан бичгийг хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.8 | Чөлөөт бүсийн 2023 онд батлагдсан төсвийг Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалын дагуу зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргах. “Алтанбулаг” чөлөөт бүсийн албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлогуудыг цагийн бүртгэлийн дагуу бодож, тухайн жилийн ээлжийн амралтыг тооцон хүн тус бүрд олгож холбогдох тайланг хуулийн хугацаанд гаргах. | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардал 752.4 сая төгрөг | 2023 оны төсөв, төсвийн төсөөллийг боловсруулсан эсэх. | Нийт албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлогуудыг цагийн бүртгэлийн дагуу бодож, тухайн жилийн ээлжийн амралтыг тооцон хүн тус бүрд олгож холбогдох тайланг хуулийн хугацаанд гаргасан. | Албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлогуудыг цагийн бүртгэлийн дагуу бодож олгосон, холбогдох тайланг хуулийн хугацаанд гаргаж баталгаажуулсан байна. | Сар бүрийн 05 болон 19-ны дотор бүсийн албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлогуудыг цагийн бүртгэлийн дагуу бодож холбогдох тайланг хүргүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт зардлын 63 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, 37 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал тус тус эзэлж байна. 2023 оны хагас жилээр ажил олгогчоос олгож буй Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 83,6 сая төгрөгөөр баталсан.<br>Нийт 34 даатгуулагчийн 668,8 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод 66,8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төсөвт төвлөрүүлсэн.<br>Тухайн татварын тайлангийн хугацаанд нийт 34 татвар төлөгчдийн 584,0 сая төгрөгийн орлогод 58,4 мянган төгрөгийн татварыг ногдуулж суутган тооцож төсөвт төвлөрүүлэн улирлын тайлан мэдээг цахим хэлбэрээр тайлагнасан. | 100 |
| 3.9 | Үндсэн хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийж ТӨБЗГ-ын өмч хөрөнгийн программд хөдлөл өөрчлөлтийг оруулах, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг ТӨБЗГ-т хүргүүлэх. | - | Үндсэн хөрөнгийн тооллогын хагас бүтэн жилийн тайлан гаргасан эсэх | 2022 оны үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын мэдээлэлжүүлэлтийн системд шивж оруулж | Үндсэн хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийх, ТӨБЗГ-ын өмч хөрөнгийн программд хөдлөл өөрчлөлтийг оруулах, шаардлагатай материалыг актлах шийдвэр гаргах. | Үндсэн хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийх, ТӨБЗГ-ын өмч хөрөнгийн программд хөдлөл өөрчлөлтийг оруулах ажлыг хуулийн хугацаанд хийхээр төлөвлөсөн.<br>2022 онд актлах хөрөнгийн саналыг ТӨБЗГ-т хүргүүлсний дагуу тогтоол гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>2023 оны захирагчийн А/18 дугаартай захирамжийн дагуу хагас жилийн тооллогын дүн, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, Захирагчийн дэргэдэх захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу тайлан балансыг нэгтгэн ажиллаж байна.<br>Өмч хамгаалах байнгын зөвлөл, Захирагчийн дэргэдэх захиргааны зөвлөлийн шийдвэрийн дагуу ТӨБЗГ-аас ирүүлсэн тогтоолын дагуу Захирагчийн дэргэдэх захиргааны зөвлөл болон Өмч хамгаалын байнгын зөвлөлийн шийдвэрээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гэрээг дүгнэсэн, статистик мэдээг гаргасан. 2022 оны хагас болон бүтэн жилийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн. | | Сэлэнгэ аймаг дахь Захирагчийн ажлын албаны байрыг актлах асуудлыг хойшлуулж шийдвэрлэсэн. | |
| 3.10 | Газрын төлбөр барагдуулах ажлын хүрээнд шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх. | - | Шүүхийн байгууллагад гаргасан нэхэмжлэлийн тоо | Өмнөх оны хүрээнд ШШГГ-т гүйцэтгэх ажиллагаа явагдаж газрын төлбөрийг барагдуулсан 7 ААН-ээс нийт 25,507,652₮ төвлөрүүлсэн. Газрын төлбөр бүрэн төлсөн 5 ААН-ээс нийт 34,723,800₮ төвлөрүүлсэн. Газрын төлбөрийг хэсэгчлэн төлж байгаа 1 ААН-ээс 2,600.000₮ | ААН-үүдтэй газрын төлбөрийн тооцоо нийлэх акт үйлдэх, газрын төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх, жилийн эцсийн тайланг баталгаажуулах. | 2023 оны байдлаар шүүхийн байгууллагад газрын төлбөр гаргуулах талаар нэхэмжлэл гаргаагүй.<br><br>2023 онд “Дөрвөн ивээл” ХХК-н газрын төлбөр болох 4,88 сая төгрөгийг шүүхийн байгууллагад нэхэмжлэх гаргаж, ШШГГ-т гүйцэтгэх ажиллагаа явагдаж, 4,88 сая төгрөгийн газрын төлбөрийг барагдуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төвлөрүүлсэн. Шүүхийн шийдвэрээр бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн 2 ААН. 10,200,000₮ Газар эзэмших эрх цуцлах тухай мэдэгдэх хүргүүлсэн 8 ААН. 2022 онд чөлөөт бүс дэхь хуулийн этгээдийн бүртгэлээс хасч, газар эзэмших эрхийг цуцалсан 10 ААН. | | | |
| 3.11 | Хөрөнгө оруулагч ААН-ийн төлбөр тооцоотой холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх. | - | Хөрөнгө оруулагч ААН-ийн төлбөр тооцооны мэдээллийн сан бүрдүүлсэн эсэх | 2022 онд 113.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс урьд оны авлагаас 19 ААН 13.2 сая төгрөг барагдуулсан. | Хөрөнгө оруулагч ААН-ийн төлбөрийн гүйцэтгэлд хяналт тавьж, өр төлбөрийг барагдуулах, бүртгэл мэдээллийн сангийн баяжилтыг хийх. | “Алтанбулаг” чөлөөт бүсэд хөрөнгө оруулсан 54-ийн ААН-ийн газар эзэмших, ашиглах журмын хавсралтын дагуу гэрээ дүгнэх актад тусгагдсан баримт бичгийн бүрдлийг шалгаж оноо өгсөн. Мөн албан бичгийн дүгнэлт болон гэрээ дүгнэсэн актыг хэвлэж ААН-рүү илгээсэн.<br>Хөрөнгө оруулагч ААН-ийн төлбөрийн гүйцэтгэлд хяналт тавьж, өр төлбөрийг барагдуулах, бүртгэл мэдээллийн сангийн баяжилтыг хийн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.12 | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд шинжилгээ хийх; | - | Аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийсэн эсэх | 2022 оны санхүүгийн тайлангийн дүн шинжилгээ хийж ажилласан. | ААН-үүдийн 2022 оны санхүүгийн тайлангийн дүн шинжилгээ /хагас, бүтэн жилээр/ | 2023 онд 5 ААН-д санхүүгийн дүн шинжилгээг хийж ажилласан.<br><br>-“Хаан ертөнц” ЧБ<br>-“Цахим ертөнц”ЧБ<br>-Тайгын шанд” ЧБ<br>-“Дундын хаалга” ЧБ<br>-“Оол монголиан интернэшнл” ЧБ | 100 |
| 3.13 | Чөлөөт бүсийн зорчигч тээврийн хэрэгсэл, бараа эргэлтийн мэдээг сар, улирал, жилээр гаргах, чөлөөт бүсэд нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэлийг хийх | - | Зорчигч тээврийн хэрэгсэл, бараа эргэлтийн бүртгэл хийсэн эсэх | Нийт 2022 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэл Дотоод тээвэр-247086, Гадаад тээвэр-602, Дотоод зорчигч-968571, Гадаад зорчигч-3117, Нийт бүсэд 9400.8 тонн бараа, бүтээгдэхүүн, Нийт орсон бараа-23,325,248.96$, Борлуулсан бараа-21,198,159.49$ | Зорчигч тээврийн хэрэгсэл, бараа эргэлтийн тайланг тухай бүр гаргасан байна. | 2023 оны тайлант хугацааны зорчигч, тээврийн хэрэгслийн болон бараа эргэлтийн мэдээ<br>Тээвэр:<br>Дотоод тээвэр- 35,251<br>Гадаад тээвэр-95<br>Зорчигчийн тоо:<br>Дотоод зорчигч-109,074<br>Гадаад зорчигч-622 зорчигч<br>Бараа эргэлт:<br>Нийт орсон бараа- 5.4 сая $<br>Борлуулсан бараа- 5.71 сая $ | 100 |
| 3.14 | Алтанбулаг чөлөөт бүсэд улсын төсвийн | - | Хяналтын үзлэгийн | Жил бүр хийгддэг | Сар бүр тогтмол эргүүл | Цэвэр ус, ариутгах татуургын барилга байгууламж шугам | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгөөр баригдсан үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй дэд бүтцийн барилга байгууламж болон бусад хөрөнгийн ашиглалт, харуул хамгаалалт, засвар үйлчилгээг тогтмол хангаж ажиллах. | | тайлан, үр дүнгийн тайлан гаргасан эсэх | байнгын үйл ажиллагаа. 25 км бохир усны шугамын бүрэн бүтэн байдлын хадгалалт хамгаалалт засвар үйлчилгээг хариуцан ажилласан түүнд гарсан гэрээтийн зардалд 16,6 сая төгрөгийн зардалтай ажилласан. | үзлэг хийж, гарсан зөрчил доголдлыг тухай бүр арилгах. | хоолой, цахилгаан байгууламж, барилгуудад Тооллогын комисс, Өмч хамгааллын зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой 2 удаа, “Комфорт импекс” ХХК-тай хамтарсан ажлын хэсгээр 1 удаа тухайн жилд нийт 3 удаагийн үзлэг шалгалт хийж засвар арчлалт, зөрчил дутагдлын илрүүлэх ажлыг зохион байгуулсан. Засвар арчлалтыг тухай бүр хийж гүйцэтгэсэн. Хөрөнгө шаардсан урсгал засварын ажлын жагсаалтыг гаргаж 2024 оны төсвийн төсөлд оруулж өгсөн. | |
| 3.15 | Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах. | Улсын төсөв 4,242.6 сая төгрөг | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 868.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. | Улсын төсөв 4,242.6 сая төгрөгийн батлагдсан төсвийн хүрээнд ажиллах. | Улсын төсөв батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагааны зардалд 1,1 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалт 3,1 тэрбум төгрөг батлагдсанаас ХБГүйцтгэлээр 1,1 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтаас 2,7 тэрбум төгрөгийн зарцуулалт хийн ажиллаж байна. Хөрөнгө оруулалт нь ЭЗХЯамнаас шууд хийгдэж чөлөөт бүс захиалагчийн хяналтыг хийж ажиллаж байна. | 100 |
| 3.16 | Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөл /Сэлэнгэ, Алтанбулаг сум/-ийн барилга угсралтын ажил гүйцэтгэх ажлын батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалтын хяналт | Улсын төсөв 4,242.6 сая төгрөг. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь. | 200.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. | Улсын төсөв 3,193.7 сая төгрөгийн батлагдсан төсвийн хүрээнд ажиллах. | Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлын хувьд 2,767,542,059 төгрөгийн бараа материал төслийн талбай дээр буусан. Барилга угсралтын ажлын хувьд 2023 оны 08.29-ний байдлаар 2,889,960,130 төгрөгний угсралтын ажил тус тус хийгдсэн байна.<br>Ажлын гүйцэтгэлийг хувьчилж бодвол 21 хувийн санхүүжилтийн гүйцэтгэлтэй 28 хувийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлтэй үргэлжилж байна.<br>2023 оны улсын төсөвт 3,193,000,000 төгрөг суусан ба үүнээс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тавьж ажиллах. | | | | | 2,689,960,130 төгрөгний санхүүжилт авсан байна. | |
| 3.17 | Байгууллагын үйл ажиллагааны 2023 оны батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу батлагдсан зардлын ангилал төрлөөр зарцуулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, өр авлага үүсгэхгүй ажиллах. | Төсвийн хүрээнд 1,048.8 сая төгрөг. | Хэмнэлтийн хувь | 668.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. | Төсвийн зарцуулалтыг холбогдох дээд байгууллагад тайлагнах. | Батлагдсан төсвийн хүрээнд өссөн дүнгээр 1.170,1 сая төгрөгийн батлагдсанаас холбогдох дүрэм журам хууль тогтоомжын дагуу хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1.170,1 сая төгрөгийн зарцуулалтыг хийн дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| 3.18 | Батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу батлагдсан зардлын ангилал төрлөөр зарцуулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах. | Төсвийн хүрээнд 219.5 сая төгрөг. | Батлагдсан төсвийн хүрээнд ажилласан эсэх | Өмнөх онд 93.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. | Байр ашиглалт, хангамж, бараа материал, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардалд 219.5 сая төгрөгийг төсвийн хүрээнд зарцуулах. | 2023 онд батлагдсан төсвөөс байр ашиглалт- 58,0 сая төгрөг, хангамж, бараа материал-2,0 сая төгрөг, эд хогшил, урсгал засвар--793,1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ-158,4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд-666,2 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэл-203,6 мянган төгрөг нэг удаагийн тэтгэмж 980,2 мянган төгрөг, тэтгэвэр тэтгэмжийн зардалд -20,6 мянган төгрөгийг зарцуулалт хийж ажилласан. | 100 |
| 3.19 | Батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал,тэтгэвэрт гарагчийн зардлыг төсвийн хүрээнд зарцуулах. | Төсвийн хүрээнд 77.8 сая төгрөг. | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Өмнөх онд 415.5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал, тэтгэвэрт гарагчийн зардлыг төсвийн хүрээнд | 2023 оны жилийн эцсийн байдлаар 6 хүнд Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 980.2 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Нийт олгосон тусламжаас өндөр настан 4 хүнд-430.2 мянган төгрөг, 2 албан хаагчид 550.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, урамшууллаас тус тус олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зарцуулах. | | |
| 3.20 | 2023 оны туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний дагуу орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. | Улсын төсөв 232.0 сая төгрөг | Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ | 2022 онд Улсын төсөвт 135.9 сая төгрөг төвлөрүүлсэн | Улсын төсөв 232.0 сая төгрөг | ЭЗХЯ-аас 2022 оны 11 дүгээр сарын 22-ний өдрийн 01/1426 тоот албан бичигт "Зөвшөөрлийн тухай" хуулийн шинэчилсэн найруулга 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжин эхлэхтэй холбогдуулан "Чөлөөт бүсэд мөрдөх журам" "Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам"-ыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулахтай холбогдуулан журмууд батлагдах хүртэл чөлөөт бүсэд газар эзэмших, ашиглах, согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгохгүй байх талаар чиглэл өгсөн.<br>2023 оны төсвийн хүрээнд төвлөрүүлэх нийт 232,0 сая төгрөгийн газрын төлбөрийн орлогыг төвлөрүүлэхээс 104,0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж байна. | 100 |
| 3.21 | Газрын төлбөрийн хураамжийн орлого төвлөрүүлэх . | Улсын төсөв 216.8 сая төгрөг | Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ | 2022 онд Улсын төсөвт 127.1 сая төгрөг төвлөрүүлсэн | Улсын төсөв 216.8 сая төгрөг | 2023 оны жилийн эцсийн 216.8 сая төгрөгийн газрын төлбөрийн хураамжийн орлогыг төвлөрүүлэн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна. | 100 |
| 3.22 | Гэрчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэх. | Улсын төсөв 200.0 мянган төгрөг | Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ | 2022 онд Улсын төсөвт 15.5 мянган төгрөг төвлөрүүлсэн | Улсын төсөв 200.0 мянган төгрөг | Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл болон тамхи худалдах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хураамжийн орлого 16.500 төгрөгийн орлого төвлөрүүлэн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна. | 100 |
| 3.23 | Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох хураамжийн орлого төвлөрүүлэх. | Улсын төсөв 10.0 сая төгрөг | Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ | 2022 онд Улсын төсөвт 6.0 сая төгрөг төвлөрүүлсэн | Улсын төсөв 10.0 сая төгрөг | Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд 2023 оны байдлаар шинээр тусгай зөвшөөрөл олгоогүй бөгөөд 11 ААН-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж улсын төсөвт 10,0 сая төгрөг төвлөрүүлэхээс тайлант хугацаанд 13,3 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. | 100 |
| 3.24 | Тамхи худалдах үйл ажиллагааны тусгай | Улсын төсөв | Улсын төсөвт | 2022 онд Улсын | Улсын төсөв 5.0 сая төгрөг | Чөлөөт бүсэд тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хүрээнд 2023 оны байдлаар шинээр тусгай зөвшөөрөл олгоогүй бөгөөд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвшөөрөл олгох хураамжийн орлого төвлөрүүлэх | 5.0 сая төгрөг | төвлөрүүл эх орлогын хэмжээ | төсөвт 2.7 сая төгрөг төвлөрүүлсэн | | 5 ААН-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж улсын төсөвт 5,0 сая төгрөг төвлөрүүлэхээс тайлант хугацаанд 1,750,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. | |
| 3.25 | Байгууллагын 2022 оны жилийн эцэс, 2023 оны хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан гаргах, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан гарган, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. *А*ж ахуйн нэгж, байгууллагуудад хуваарилж буй газар олголт, газрын төлбөр хураамж болон авлагыг байгууллагын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт зэрэг мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж хэвшсэн | 100 |
| 3.26 | Үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн ашиглалт хамгаалалт, хяналтыг сайжруулан ажиллах болон урсгал засварын нэгдсэн төсөв гаргаж хэрэгжүүлэх. | - | Үйл ажиллааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Төсвийн тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгох, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, өр авлага үүсгэхгүй байх, сахилга батыг чангатгах, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэхэд анхааран байгууллагын 2023 оны үйл ажиллагааны орлого, урт хугацаанд үүссэн авлагыг бүрдүүлэн ажиллахад хяналт тавин ажиллаж байна.<br>Өмч хамгааллын байнгын зөвлөлтэй хамтран 2023 оны хөрөнгө оруулалтын 3,1 тэрбум төгрөгийн төсвийн хүрээнд хяналт тавьж ажиллаж байна.<br>/Дэд бүтцын хэлтэс болон PMIS програмд оруулсан саналын гүйцэтгэлээр /Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний зардалд Барилга хот байгуулалтын яамны 2022 оны төсөвт 214.9 сая төгрөг батлагдаж он дамжсан төсвөөр ерөнхий төлөвлөгөөний ажил болон улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх дэд бүтцийн цахилгааны өргөтгөл шинэчлэлийн ажилд 3.2 тэрбум төгрөгт багтаан төсвийн дагуу хэрэгжилтийн ханган ажиллаж байна. 04 дүгээр улирлын байдлаар 3,1 тэрбум төгрөгийн зарцуулалтыг дээд шатны байгууллагаас шууд шилжүүлсэн болно. | 100 |
| 3.27 | Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, сайжруулах дүгнэлт гарган ажиллах. | - | Байгууллагын дотоод хяналт шалгалт хийсэн | 2023 онд шинээр хийгдэх ажил. | Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, | Монгол улсын Засгийн газрын 2011 оын 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө гарган батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эсэх | | сайжруулах дүгнэлт гаргаж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх. | | |
| 3.28 | Чөлөөт бүсийн үйл ажиллагааг таниулах ажлын хүрээг тэлэх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах, www.altanbulag.gov.mn веб сайтад байгууллагын талаарх мэдээ, мэдээллийг орос, англи, хятад хэл дээр орчуулан байршуулж олон нийтэд цаг тухайд нь хүргэх | - | Мэдээ, мэдээллийн тоо | Байгууллагын www.altanbulag.gov.mn вебсайтад чөлөөт бүсийн үйл ажиллагааны мэдээг тогтмол байршуулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан. www.altanbulag.gov.mn веб сайтад бүсийн талаарх мэдээ, мэдээллийг орос, англи, хятад хэл дээр хөрвүүлэн байршуулан олон нийтэд цаг тухайд нь хүргэн ажилласан. 2022.09.10-ны өдөр Сүхбаатарын талбайд | Чөлөөт бүсийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх ажил хийгдсэн байх. | www.altanbulag.gov.mn веб сайт, “Алтанбулаг” чөлөөт бүс хөрөнгө оруулагч” фейсбүүк группд 52 багц мэдээ мэдээлэл бэлтгэж оруулалаа.<br>-“Алтанбулаг” чөлөөт бүсийн ерөнхий шинэчилсэн дэлгэрэнгүй танилцуулга, товч мэдээлэл, бэлтгэж орос, хятад дээр орчуулагдан тавигдсан.<br>- Байгууллагын вэб сайтад мэдээ, мэдээллийг орос, хятад хэл дээр хөрвүүлэн байршуулсан.<br>- ОХУ-ын Эрхүү мужийн ажил хэргийн “Капиталист” сэтгүүлд бүсийн тухай сурталчлан таниулах ажил хийгдсэн.<br>-“Алтанбулаг” чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч нарт зориулсан гарын авлагын /тараах материал/ хэвлэлийн компаниудын үнийн судалгаа, веб сайтуудын хөгжүүлэлт хийх компаниудын судалгаа хийж, 33-д танилцуулсан гэрээ хийгдэж байна. -Гарын авлага-т мөн шинэчилсэн цахим хуудсанд орох материал орос, англи, хятад хэл дээр бэлтгэн явагдаж байна. | 99 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | НҮБ, ЭЗХЯ-наас хамтран зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн зорилго” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон. | | | |
| 3.29 | Сүлжээний аюулгүй байдлыг ханган ажиллах. Компьютер, түүний дагалдах хэрэгслийн засвар үйлчилгээг хийх. | Мэдээлэл, технологийн зардал | Холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлсэн эсэх | Дотоод сүлжээний найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем. “Open VPN” хэрэглэгчийн програм. Гаалийн деклараци олголтыг хялбаршуулах, цахимжуулах арга хэмжээ. “Алтанбулаг” чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн | Техник технологи, дотоод сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах, кибер халдлагаас хамгаалах, компьютер болон түүний дагалдах хэрэгслийн засвар, үйлчилгээг хангах. | -Албан хаагчдын компьютерийн хүчин чадлын судалгааг хийж, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх асуудлыг удирдлагадаа танилцуулсан.<br>-Үндэсний дата төвтэй холбогдож “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны цахим шуудангийн админы нэвтрэх эрхийг сэргээж, мөн зарим албан хаагчдын цахим шуудангийн нэвтрэх нууц үгийг сэргээсэн./мэдээллийн аюулгүй байдлын үүднээс 3 сар тутам нууц үг шинэчилж байна/<br>- Үндэсний Дата Төвийн хуульч Б.Мөнхзүслэн, Ган-Эрдэнэ нартай холбогдож чиглэл, зөвлөмж авч хамтран ажилласан.<br>-Монгол улсад интернетийн үйлчилгээ явуулдаг компаниудын судалгааг хийж танилцуулан улмаар цаашид Жи мобайлын интернэтийг ашиглахаар болж, холболтын гэрээ байгуулан бага өртгөөр өндөр хурдны интернэтийг ашиглаж байна.<br>- Аж ахуйн нэгжүүдийг ГЕГ-ийн CAIS системд холбуулах ажлын хүрээнд “Активишн” ХХК-тай хамтран хөрөнгө оруулагчдын бараа бүтээгдэхүүнийг CAIS системд бүртгүүлэх талаарх танилцуулга Zoom хурлыг зохион байгуулсан | 99 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | этгээд бүртгүүлэх, бүртгэлийн гэрчилгээг E-Mongolia системээр мэдүүлж авахаар болсон. | | | |
| **Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт** | | | | | | | |
| 4.1 | “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн ХТП-1-8, РП-1,2 барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулалтын ажлыг дуусгуулах. | Томилолтын зардал. | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн түр шугам | ХТП-1-8, РП-1,2 барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулалтын ажлыг дуусгуулах | 1. Алтан булаг чөлөөт бүсийн 35/10кВ-ын 2*4000 чадалтай дэд станцын барилгын суурь ухаж ул бетон цутгах, суурь хийх, Барилгын өрлөгийн ажил 100%, бүс бетон цутгасан, хучилтын хавтан тавигдсан, дотор шавар хийгдсэн, дотор цахилгааны монтажийн ажил тус тус хийгдсэн. Барилга угсралтын ажил 90 хувьтай үргэлжилж байна.<br>2. РП-1,2 дээр суурийн нүх ухсан, ул бетон цутгасан, суурийн ажил хийгдсэн, ялуу тавьсан, зоорийн давхарын хучилт хийгдсэн, РП-2 барилгын өрлөгийн ажил хийгдсэн. Барилга угсралтын ажил 70 хувьтай үргэлжилж байна.<br>3. ХТП-1,5,6,7,8 дээр суурь ухсан, ул бетон цутгасан, суурь хийгдсэн, хучилт тавигдсан байна. Барилга угсралтын ажил 50 хувьтай үргэлжилж байна.<br>ХТП-2,3,4 дээр суурийн нүх ухагдсан, ул бетон цутгасан, суурь хийгдсэн байна. Барилга угсралтын ажил 30 хувьтай үргэлжилж байна | 80 |
| 4.2 | “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах. Орон нутагт ажлын талбайг гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх. | - | Гэрээ. Ажил хүлээлцэх акт байгуулсан эсэх | “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн түр шугам. | “Алтанбулаг” чөлөөт бүсийн болон Алтанбулаг сумын цахилгаан хангамжийн хүчин чадал нэмэгдэнэ. | “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөлтгөлийн ажлыг гүйцэтгэх гэрээ 2022 оны 03 дугаар сарын 30-нд байгуулагдсан.<br>Захиалагчийн хяналтын гэрээ №ЭХҮТ/09/2022 нь 2022 оны 10 дугаар сарын 24 өдөр байгуулагдсан.<br>Зохиогчийн хяналтын гэрээ №22/02 нь 2022 оны 07 дугаар сарын 22 өдөр байгуулагдсан.<br>Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай №АБ-03/23 нь 2023 оны 11 дүгээр сарын 23 өдөр байгуулагдсан.<br>Зохиогчийн хяналт хийх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухай №АБ-02/23 нь 2023 оны 11 дүгээр сарын 23 өдөр эхэлсэн.<br>2022 оны 7-р сарын 8-ны өдөр орон нутагт ажлын талбайг гүйцэтгэгчид хүлээлгэн өгч барилгын улаан шугам тавих ажил эхэлсэн. | |
| 4.3 | “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллах. | 2,000,000 төгрөгийн төсөв шаардлагатай. | Захиалагчийн хяналт тавьсан баримт бичгийн тоо | Сэлэнгэ Алтанбулагийн 25 км бохир усны шугам хоолойн цахилгаан хангамжийн ажил. | “Алтанбулаг” чөлөөт бүсийн болон Алтанбулаг сумын цахилгаан хангамжийн хүчин чадал нэмэгдэнэ. | “Алтанбулаг” чөлөөт бүс, “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХК, “Улаанбаатар электромонтаж” ХХК-ийн гурвалсан Захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ №ЭХҮТ/09/2022 нь 2022 оны 10 дугаар сарын 24 өдөр байгуулагдсан.<br>1. **Сүхбаатар 110/35/6кВ-ын 2*25МВА дэд станцын өргөтгөлийн угсралтын ажил:** Алтан булаг чөлөөт бүсийн 5,264,054,560 (энэхүү ажил нь дэд станцын цахилгаан угсралт 4,790,421,511 төгрөг, ил хувиарлах байгууламжийн угсралт 473,633,049төгрөг) төгрөг бүхий 110/35/6кВ-ын 2*25мВА чадалтай Сүхбаатар дэд станцын өргөтгөлийн ажлын материал захиалга БНХАУ-ын COTTOH ELECTRIC LLC компанид захиалагдсан ба 2024 онд нийлүүлэхээр төлөвлөсөн. Ажлын гүйцэтгэл 0 хувьтай байна.<br>2. **35кВ-ын 1 хэлхээт 21,4км ЦДАШ-ын АС утас солих угсралтын ажил:** 35кВ-ын 1 хэлхээт 21,4км цахилгаан дамжуулах агаарын шугамын утас солих 539,895,538 төгрөгний угсралтын ажлын бараа материал талбай дээр 2023.09.10-ны дотор буухаар худалдан авалт хийсэн ба ажлыг 2023.10.01-ний дотор хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>3. **35кВ-ын 1 хэлхээт 4км ЦДАШ шинээр угсрах угсралтын ажил:** 35кВ-ын 1 хэлхээт 4км цахилгаан дамжуулах агаарын шугам угсрах 682,889,070 төгрөгний угсралтын ажил 100 хувь бараа материал талбай дээр бууж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тулгууруud 100% боссон ба АС утас татах ажил хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>4. **35/6кВ-ын 2*4000кВА чадлын дэд станцын угсралтын ажил:** Алтан булаг чөлөөт бүсийн 2,321,005,579 (энэхүү ажил нь дэд станцын цахилгаан угсралт 1,813,771,859 төгрөг, ил хувиарлах байгууламжийн угсралт 300,290,544, 10кВ-ын барилгын ажил 206,943,176 төгрөг) төгрөг бүхий 35/10кВ-ын 2*4000 чадалтай дэд станцын барилга угсралтын хувьд 206,943,176 төгрөгний 10кВ-ын барилгын ажил 100 хувь дууссан. 1,813,771,859 төгрөгний дэд станцын цахилгаан угсралтын ажлын бэлтгэл ажил хийгдсэн материал захиалга БНХАУ-ын COTTOH ELECTRIC LLC компанид захиалагдан үйлдвэрээс ачигдаж төслийн талбай дээр буусан. 300,290,544 төгрөгний суурийн ажлын материал талбай дээр буусан ажил эхлэн үргэлжлэн хийгдэж байна. Тус ажлын бараа материалын хувьд 100 хувь талбай дээр буусан. Ажлын нийт гүйцэтгэлийн хувьд 50 хувьтай байна.<br>**5. 6кВ-ын хаалттай хуваарилах байгууламж РП-2ш зоорийн барилгын хамт угсрах угсралт:** Алтан булаг чөлөөт бүсийн 1,910,349,232 (энэхүү ажил нь дэд станцын цахилгаан угсралт 1,646,374,842 төгрөг, барилгын ажил 263,974,390 төгрөг) төгрөг бүхий 2ком хувиарлах байгууламж /РП/ барилга угсралтын хувьд 263,974,390 төгрөгний барилгын ажил 80 хувьтай үргэлжилж байна. 1,646,374,842 төгрөгний дэд станцын цахилгаан угсралтын ажлын материал захиалга БНХАУ-ын COTTOH ELECTRIC LLC компанид захиалагдсан 09 сард нийлүүлэгдэхээр төлөвлөсөн. Ажлын нийт гүйцэтгэлийн хувьд 11 хувьтай байна.<br>**6. 6/0,4кВын 2*630кВА чадалтай ХТП болон барилга угсралтын ажил:** Алтан булаг чөлөөт бүсийн 1,907,992,279 (энэхүү ажил нь дэд станцын цахилгаан угсралт 1,350,342,504 төгрөг, барилгын ажил 557,649,776 төгрөг) төгрөг бүхий 8ком хаалттай хувиарлах байгууламж /ХТП/ барилга угсралтын хувьд 557,649,776 төгрөгний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барилгын ажил 50 хувьтай үргэлжилж байна. ХТП-1,2,3,4,5,6,7,8 барилгын газар шорооны ажил, суурийн ажил, хийгдсэн ХТП-5,6,7,8 шал сувагчлалын ажил хийгдсэн өрлөгийн ажил хийгдэж эхлэсэн. Цахилгаан тоноглол угсралтын ажлыг 11 сард хийхээр төлөвлөж байна. Нийт ажлын гүйцэтгэл 11,6 хувьтай үргэлжилж байна.<br>7. **10кВ-ын ЦДКШ-н угсралт:** 10кВ-ын ЦДКШ-ын угсралтын ажил 2,670,481,759 төгрөг бүхий ажил 2024 онд хийгдэхээр байна гүйцэтгэл 0 хувь.<br>Захиалагчийн техник хяналтыг “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХК хийж байгаа явцын хоёр тайлан хийгдсэн. | |
| 4.4 | БНСУ-ын Котра байгууллага болон Зам тээврийн яамтай чөлөөт бүсийн логистикийн ТЭЗҮ болон зураг төсөл дээр хамтран ажиллах | - | Хамтран ажилласан эсэх | “Нью урбанизм” ХХК-ийн хийсэн судалгаа. | “Алтанбулаг” чөлөөт бүсэд логистикийн бүс байгуулагдах эхлэл тавигдана. | “Алтанбулаг” чөлөөт бүсэд логистикийн бүс байгуулагдах эхлэл тавигдах зорилгоор БНСУ-ын КОТРА болон “ Нью урбанизм” ХХК чөлөөт бүсэд судалгаа хийгдсэн. 3 удаагийн хамтарсан хурал зохион байгуулсан. 2022.11.02 өдөр Эдийн засаг, хөгжлийн яамд эцсийн тайлан тавьсан. Уг<br>ТЭЗҮ судалгааны дагуу “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэж буй “Идеал групп” ХХК-д ерөнхий төлөвлөгөөнд тусгуулах санал хүргүүлсний дагуу зураг төслийг тусгуулсан болно. | 100 |
| 4.5 | Цахилгаан хангамжийн дэд өртөөнүүд, цахилгаан дамжуулах агаарын шугамуудад тогтмол үзлэг хийж, үзлэгээр илэрсэн зөрчлийг цаг тухайд нь арилгах, хяналт тавих. | Шатахууны зардал: 250.000 төг. Бичиг хэргийн зардал: 25.000 төгрөг. | Цахилгаан хангамжийн дэд өртөөнүүд, цахилгаан дамжуулах агаарын шугамууд тогтмол үзлэг хийсэн тайлан гарсан эсэх | Жил бүр тогтмол хийгддэг ажил. | Үзлэгээр илэрсэн зөрчлийг цаг тухайд нь арилгаж ажиллана. Эрчим хүч нийлүүлэх гэрээний хэрэгжилтийг хангах. | Цахилгааны аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын зааврын дагуу сар бүрийн үзлэг шалгалт, улирлын засвар үйлчилгээ, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Сар бүрийн үзлэг шалгалтаар 11 гэмтэл зөрчлийг илрүүлж устгасан.<br>Улирлын засвар үйлчилгээгээр ЦДАШ-уудад үзлэг шалгалт хийгдсэн. Трансформаторуудын тос, изолятор зэргийг шалгасан. Шаардлагатай засвар үйлчилгээг хийсэн.<br>Өвөлжилтийн бэлтгэл хангаж ХТП-521, КТП-424-нүүдийн дамжуулагч шинийг цэвэрлэж, чангалж, туслах 0.4 кВ-ын хувиарлах самбаруудын автомат, кабелиудын холбоосыг чангалж, үзлэг хийсэн.<br>Гэнэтийн гэмтэл саатал: 2023 оны 8 дугаар сарын 5, 12-ны өдрүүдэд орсон усархаг аадар дуу цахилгаантай бороо орсоны улмаас ЦДАШ-ын өндөр талын цэнэг шавхагч | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэмтсэнийг сольж, шугамын үзлэг хийж хэвийн байдалд оруулж хүчдэлд залгасан. | |
| 4.6 | “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн барилгын эскиз зурагт тавигдах шаардлага, барилгын норм ба дүрмийн дагуу боловсруулсан эсэхэд хяналт тавьж ажиллах. Мэргэжлийн талаас заавар зөвлөмж өгөх. | Бичиг хэргийн зардал: 50.000 төгрөг | Барилга байгууламжийн батлагдсан эскиз зураг боловсруулсан эсэх | Жил бүр тогтмол хийгддэг ажил. | Бүсэд баригдаж байгаа барилга байгууламжид “Барилгын тухай” хуулийн дагуу тухай бүр хяналт тавьж ажиллах | Чөлөөт бүсийн ААН-дийн шинээр ашиглалтанд өгсөн барилгуудын ерөнхий төлөвлөлтийн зураг 2ш, барилгын далд ажлын актууд, ил ажлын актууд нийт 264 хуудас бичиг баримт бүрдүүлсэн.<br><br>А3 хэмжээтэй эскиз -80ширхэг<br>А4 хэмжээтэй эскиз-6ширхэг батлагдаж архивлагдсан.<br><br>СЕКЮР ФИНАНС ТРЕЙЛ ЧБ ХХК, ЦАРАМТ ОВОО ЧБ ХХК, АБСОЛЮТ ТРАНС ЧБ ХХК-ний барилгад мэргэжлийн комисс ажиллуулж ашиглалтад авсан.<br><br>“Чансаа ЧБ ХХК, Дунд голын шанд ЧБ ХХК-ний хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх асуудлаар 2 удаа мэдэгдэл хүргүүлсэн.<br><br>Шинээр баригдсан нийт-4 барилга объектийн барилгын ажилд хяналт тавьж анхан шатны бичиг баримтын бүрдлийг хангахад хяналт тавьж баталгаажуулан Улсын коммист хүлээлгэн өгсөн.<br><br>Нийт-5 ААН-н тохижилт сайжруулалтын ажилд хяналт тавьж 6 удаагийн зааварчлага өгсөн. | 100 |
| 4.7 | “Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж буй Аж ахуйн нэгжүүдийн барилга угсралтын ажилд барилгын норм дүрмийн дагуу хяналт тавих, барилга угсралтын ажил эхлүүлэх баримт бичгийн бүрдлийг хангах. | Бичиг хэргийн зардал: 50.000 төгрөг | ААН-ийн барилга угсралтын ажил эхлүүлэх үргэлжлүүлэхэд бүрдүүлэх бичиг баримт, барилга угсралтын ажилд барилгын | Жил бүр тогтмол хийгддэг ажил. | “Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж буй Аж ахуйн нэгжүүдийн БУА эхлүүлэх үргэлжлүүлэхэд бүрдүүлэх бичиг баримтыг бүрдүүлж, барилга угсралтын ажилд барилгын норм | Нэг бүс нэг зам нэг зорилго” ХХК, “Жагротех чөлөөт бүс” ХХК, “Минзано чөлөөт бүс” ХХК, “Силк рөүд интернейшнл чөлөөт бүс” ХХК-ны барилга угсралтын ажил дуусч улсын комисст хүлээж авав.<br><br>“Абсолют транс чөлөөт бүс” ХХК-ны барилгыг улсын комисс ажилж хүлээж авав.<br>Эко иннова винд” ХХК-ны кадастрын зургийг гаргуулж актжуулсан. Эскиз зурагтай танилцаж заавар зөвлөмж өгөв.<br><br>“Монхор орд констракшн” ХХК, “Бака транс чөлөөт бүс” ХХК-ийн ажлын зурагтай танилцаж баталгаажуулав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | норм дүрмийн дагуу хяналт тавьсан тухай тайлан баримт бичгийн бүрдлийг хангасан эсэх | | дүрмийн дагуу хяналт тавьж барилга угсралтын ажлыг явуулах. | “Харц ард” ХХК-ийн архитектур төлөвлөлтийн даалгавар өгч цаашид барилга барих, зураг төсөл боловсруулах ажлын дараалал /график/ талаар зааварчилгаа өгөв.<br><br>“Дархан трейд” ХХК-ийн архитектур төлөвлөлтийн даалгавар өгч эскиз зурагтай танилцаж батлав.<br><br>“Хур ирмүүн билэг чөлөөт бүс” ХХК-ны эскиз зурагтай танилцаж батлав.<br><br>“Агмарко чөлөөт бүс” ХХК-ны эскиз зурагтай танилцаж зурагт шаардлагагад нийцэхгүй байгаа фасад, өнгө үзэмж загвар дизайн өөрчөх талаар шүүмж тавьж буцаав.<br><br>“Таванхан хайрхан” ХХК-ны эскиз зурагтай танилцаж батлав.<br><br>Барилга угсралтын ажил дуусаагүй 8 обьект байна. | |
| 4.8 | Цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усны шугамд холбогдохыг хүссэн, бүсэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид техникийн түр нөхцөл олгож, холболт хийлгэх, холболтын ажилд хяналт тавих. | Бичиг хэргийн зардал: 50.000 төгрөг | Техникийн нөхцөл олгосон эсэх | Жил бүр тогтмол хийгддэг ажил. | Цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усны шугамд холбогдохыг хүссэн бүсэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид техникийн нөхцөл олгож, холболтын ажилд хяналт тавьж ажиллах. | Чөлөөт бүсэд шинээр баригдаж буй барилгад инженерийн шугам сүлжээнд холболтыг эскиз зураг болон ажлын зураг боловсруулахад шаардлагатай бол заавар зөвлөмж өгнө ажиллаж байна.<br>“Дархан нэхий” ХХК-ны ажлын зураг төсөлд техникийн норм, дүрмийг баримтлан хамгийн ойроос татах цэвэр, бохир усны худгуудыг холбох худгийг зааж өгөв.<br>“Таванхан” ЧБ ХХК-д цахилгаан эрчим хүч шинээр хэрэглэгчийн тодруулга хуудас өгсөн.<br>“Царамт овоо ЧБ”, Сэкюр финанс ЧБ”, “Дунд голын шанд ЧБ”, Абсалют транс ЧБ” ХХК-ниуд хүсэлт тавьсаны дагуу цахилгаан техникийн нөхцөл олгосон.<br>“Эко энова винд” ХХК нь хүсэлт тавьсаны дагуу техникийн нөхцөл боловсруулсан.<br>“Дунд голын шанд ЧБ” ХХК нь техникийн нөхцлөө авч хүсэлт тавьсаны дагуу Монромдиум ХХК-ний хувиарлах самбараас хүчдэлд холбосон. | 100 |
| 4.9 | 2023 оны газар олголтын | Бичиг хэргий | 2023 оны газар | 2023 онд газар | Газар ашиглах эрх олгох | “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд “Идеал групп” ХХК-тай хамтран | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөг боловсруулж, “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн газар ашиглах эрхийг төсөл сонгон шалгаруулах дуудлага худалдааны аль нэг хэлбэрээр зохион байгуулах. | н зардал | олголтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан эсэх | олгогдсон тоо. | ажлыг зохион байгуулж, газар ашиглагчтай гэрээ байгуулсан байна. | ажиллаж байгаа бөгөөд ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаатай холбоотойгоор ерөнхий төлөвлөгөөнд оруулах саналыг албан бичгээр хүргүүлсэн.<br>Ерөнхий төлөвлөгөөний хүрээнд худалдааны талбайн аж ахуй нэгжүүдэд төлөвлөгөөний талаар танилцуулж, саналыг авч холбогдох байгууллагад нь албан бичиг хүргүүлсэн<br><br>“Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.7 заасны дагуу Засгийн газраар эцэслэн батлагдсаны дараа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн 2023 оны газар олголтын төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу аж ахуйн нэгж байгууллагуудад газар ашиглуулах ажлыг зохион байгуулна. | |
| 4.10 | Газрын харилцаа, геодези зураг зүйн газартай хамтран кадастрын мэдээллийн сангийн “Ленд-менежер” программын нэмэлт хөгжүүлэлтийн дагуу хийгдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх. | Бичиг хэргийн зардал: 80.000 төг | Програм хөгжүүлэлт хийсэн эсэх | “Ленд-менежер программыг 2019 оноос үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. | ГХГЗЗГ-тай хамтран кадастрын мэдээллийн сангийн “Ленд-менежер программыг нэвтрүүлж программын нэмэлт хөгжүүлэлтийг нэвтрүүлнэ. | Кадастрын мэдээллийн сангийн “Ленд-менежер программын нэмэлт хөгжүүлэлтийг  өдөр тутмын ажил үүрэгтээ нэвтрүүлэн ажиллаж байна.<br>Программ шинэчлэлтэй холбоотойгоор нэгдсэн мэдээллийн сангийн WEB тохиргоог 06 сарын 14 болон 08 дугаар сарын 30-ны өдөр нийт 2 удаа шинээр уншуулсан бөгөөд шаардлагатай үед Газрын харилцаа геодези зураг зүйн газарт хандан программ хангамжийг хариуцан ажиллаж байна. | 100 |
| 4.11 | “Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын газрын гэрээг дүгнэх . | Бичиг хэргийн зардал: 50.000 төг | Гэрээний биелэлтийг дүгнэсэн эсэх | 2023 онд шинээр хийгдэх ажил. | Газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын газрын гэрээг дүгнэсэн байна. | Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшигч, ашиглагч нийт 131 иргэн аж ахуй нэгжийн 150 нэгж талбараас гэрээний хугацааг дүгнэх 130 нэгж талбарын хөрөнгө оруулалтын гэрээ болон газар эзэмших, ашиглах гэрээг нэгтгэн дүгнэж, акт үйлдэн, гэрээг дүгнэх ажлын хэсгийн гишүүдээр баталгаажуулан аж ахуй нэгж тус бүрд албан бичгээр хүргүүлсэн.<br><br>-Тухайн газар дээрээ хөрөнгө оруулалт хийсэн буюу барилга бүтээн байгуулалтын ажил хийж гүйцэтгэсэн нийт 54 нэгж талбараас 37 нэгж талбар нь бүрэн хангалттай, хангалттай дүгнэгдэж, 17 нэгж талбар нь хугацаатай үүрэг хүлээхээр дүгнэгдсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Тухайн газар дээрээ барилга бүтээн байгуулалт хийгээгүй 66 нэгж талбараас 30 нэгж талбар нь хангалттай болон хугацаатай үүрэг хүлээхээр дүгнэгдэж, 36 нэгж талбар нь хангалтгүй дүгнэгдэж мэдэгдэл хүргүүлсэн болно.<br>-Бүтээн байгуулалтын ажил эхлүүлээгүй аж ахуй нэгжүүдэд хүргүүлсэн албан бичгийн хавсралтаар барилга бүтээн байгуулалтын ажил хийж гүйцэтгэхэд шаардагдах баримт бичгийг хэрхэн авах талаарх гарын авлагыг давхар хүргүүлсэн байна.<br>Мэдэгдэл хүргүүлсэн албан бичгийн дагуу нийт 24 аж ахуй нэгжээс хариу ирүүлсэн байна. Гэрээ дүгнэсэн ажлын хүрээнд нийт 2022 оны эцсийн байдлаар 46.997.279 төгрөгнийн газрын төлбөрийн авлага үүссэн байснаас 33.300.000 төгрөгийг төвлөрүүлж 71 хувийн гүйцэтгэлийг хангасан. | |
| 4.12 | “Алтанбулаг” чөлөөт бүсийн цэвэр ус хангамжийн 7 худгийг бүрэн ажиллагаанд оруулахад “Комфорт импекс” ХХК-ий ажилд хяналт тавих. | | Бүрэн ажиллагаанд орсон худгийн тоо. | Одоо хийгдсэн байгаа ажлын тоо хэмжээ. | Худгуудийг бүрэн ажиллагаанд оруулах. | Цэвэр усны долоо худгийн барилга байгууламж, бохир усны худгуудын дээврийн төмөр усны хаялаг алга болсноор ханын шавардлага нурж унасан. Гадна пасадны өнгөлгөө будаг хуурч унасан. Мөн байгалийн давагдашгүй хүчин, элэгдэлд орсон байдалтай буй дэд бүтцийн барилга байгууламж сэргээн засварлах ажлын санхүүжилтийг 2024 оны улсын төсөвт суулгахаар санал хүргүүлсэн.<br>Цэвэр усан хангамжийн 7 худгийг бүрэн ашиглалтад оруулахад техникийн шаардлага хангагдахгүй тул сэргээн засварлах ажлын хэсгийг “Комфорт импекс” ХХК-тай хамтран 2023 оны 09 сарын 25-ны өдрийн А/37 дугаар захирамжаар байгуулсан.<br>2023 оны 10 сарын 02-ны өдөр “Комфорт импекс” ХХК-тай “Алтанбулаг” чөлөөт бүс дээр уулзалт зохион байгуулж хурлын протокол хөтлөн, 7 худгуудаар явж хийгдэх ажлын жагсаалт гаргасан. 1-с 7 дугаар худгуудад хийгдэх ажилуудын жагсаалтанд:<br>• Цахилгааны холболтыг гүйцээх.<br>• дотор цахилгааны монтажийг дүрмийн дагуу хийж гүйцэтгэх.<br>• Трансформаторын тулгуур хазайсныг тэгшлэх.<br>• Ажлын тавцан хийх, буултын утсыг солих 0,4кВ-н кабелийн | 98 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | изоляци хагарсан солих.<br>• Газардуулгын полосаг гагнах нөхөх, Борооны усны хаягчийг шинэчлэх.<br>• Гадна фасадны тоосго элэгдэлд орсон.<br>• Шавардаж засварлах,<br>• Гадна фасадны тоосго илэгдэлд орсон.<br>• Шавардаж засварлах, Яндан нүхийг насосны хаpалдаа болгон шинээр цоолох, лүүк, малгай, таг хийх.<br>• Хуучин нүхийг бөглөх,<br>• Гүнийн худгийн 1-р насос унасан эсэхийг үзэж шалгах.<br>• Худгийг лайдаж насосыг суулгах<br>• Насос болон шахах шугамыг холбох, Дотор заслыг сэргээх. хийлгэхээр тусгав. | |
| 4.13 | “Алтанбулаг” чөлөөт бүсийн ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламжийн угсралтын ажилд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, байнгын ашиглалтад хүлээн авах. | - | Арилгасан зөрчил, дутагдлын тоо | Жил бүр тогтмол хийгддэг ажил. | Зөрчил дутагдлыг цаг тухай бүрт арилгах, шугам сүлжээг ашиглалтад хүлээлгэн өгснөөр аж ахуй нэгжүүд цэвэр бохир усны асуудал шийдэгдэнэ. | 2023 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийн хүрээнд, Байгууллагын өмч хөрөнгийн тооллогын батлагдсан удирдамжийн дагуу “Алтанбулаг” чөлөөт бүсийн Усан хангамжийн барилга байгууламж, тоног төхөөрөмжид хяналт тавихад хэд хэд зөрчил дутагдал илэрсэн. Тус ажлыг хийж гүйцэтгэсэн “Комфорт импекс” ХХК -д зөрчил дутагдлыг арилгуулах, дутуу ажлыг хийж гүйцэтгүүлэх талаар албан бичиг хүргүүлэв.<br>Илэрсэн зөрчил дутагдалууд:<br>Чөлөөт бүс дээрх Цэвэр усны 7 худгийн байшингийн дээвэр муудсан ус орсноос тоосгон хана нурж байгаа.<br>Бохир усны худгуудын дээврийн төмөр усны хаялаг алга болсноос ус орж хананы шавардлага нурж унасан.<br>Гадна пасадны өнгөлгөө будаг хуурч унаж өнгө үзэмжийг сайжруулах, торон хашааны шонгуудыг солих шаардлагатай<br>Цахилгаан монтажны ажлуудыг хийлгэх шаардлагатай “Комфорт импекс” ХХК-р хийлгэхээр гэрээ, ажлын төлөвлөгөө гаргаж байна. Эдгээр дутуу ажлыг хийж гүйцэтгэснээр байнгын ашиглалтанд хүлээн авах боломжтой болно. | 100 |
| 4.14 | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд цэвэр, | - | Цэвэр бохир усны шугамд холбогдох | Жил бүр тогтмол хийгддэг ажил. | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд | “Дархан нэхий” ХХК-ны ажлын зураг төсөлд техникийн норм, дүрмийг баримтлан хамгийн ойроос татах цэвэр, бохир усны худгуудыг холбох худгийг зааж өгөв.<br>Чөлөөт бүсэд шинээр баригдаж буй барилгад инженерийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бохир усны шугамд холбогдох техникийн түр нөхцөл олгох, холболтын ажилд хяналт тавих. | | ыг хүссэн, бүсэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл тэй аж ахуйн нэгжид олгох техникийн нөхцөл олгосон эсэх | | техникийн нөхцөл олгосноор шинээр баригдаж буй барилга байгууламж нь инженерийн шугам сүлжээнд холболт хийлгэх боломж бүрдэнэ. | шугам сүлжээнд холбогдох ажлын зураг боловсруулахад шаардлагатай бол заавар зөвлөмж өгнө ажиллаж байна. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумыг "Жишиг сум" төслийн хүрээнд хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд тус сумын цэвэрлэх байгууламжийг "Нишин илч" ХХК хийж гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэж өгсөн бөгөөд уг цэвэрлэх байгууламжид “Алтанбулаг” чөлөөт бүсийг холбуулах талаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын засаг даргад хүсэлт тавьж холбуулсан. Одоогоор цэвэрлэх байгууламжийн туршилт тохируулгын ажил хийгдэж байна. | |
| 4.15 | Алтанбулаг” чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжүүдийн дулааны эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах. Заавар зөвлөмж тогтмол өгч тайлан гаргах | - | Аж ахуй нэгжүүдийн дулааны эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдалд шалгалт хийсэн тайлан. | Жил бүр тогтмол хийгддэг ажил. | Аж ахуй нэгжүүдийн дулаан эрчим хүчний найдвартай , аюулгүй байдал хангагдана. | Бүсэд барилга байгууламжтай 50 аж ахуй нэгжээс 26 аж ахуй нэгж цахилгаан хангамжид холбогдсон.<br>Цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжүүдэд сар бүр ээлжит үзлэг шалгалт хийж, цэвэрлэгээ чангалгаа хийгдсэн. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангасан. ХТП-521, КТП-424-нүүдийн дамжуулагч шинийг цэвэрлэж, чангалж, туслах 0.4 кВ-ын хувиарлах самбаруудын автомат, кабелиудын холбоосыг чангалж, үзлэг хийсэн. | 100 |
| 4.16 | “Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж байгаа болон шинээр газар эзэмшиж, ашиглах аж ахуйн нэгж байгууллагуудад нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлүүлэх мэдэгдэл олгох, кадастрын зургийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж мэдээллийн санд оруулах. | Бичиг хэргийн зардал: 100.000 төгрөг | Аж ахуйн нэгж байгууллагын нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлүүлсэн мэдэгдэл, кадастрын зураг. | Жил бүр тогтмол хийгддэг ажил. | Кадастрын зургийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж мэдээллийн санд тухай бүрд нь оруулсан байна. | Тайлант хугацаанд “Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшигч, ашиглагч нийт 13 аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу газрын гэрчилгээ болон кадастрын зургийг цахимжуулж мөн тухайн эдэлбэр газар дээрээ барьсан барилгын суурийн цэгүүдийг мэргэжлийн байгууллагаар хэмжсэн хэмжилтийн координатын дагуу газрын нэгдсэн мэдээллийн санд оруулж, мэдээллийг шинэчлэн, шаардлагатай материалыг холбогдох аж ахуй нэгжүүдэд хүргүүлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.17 | “Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд эзэмшлийн газартаа хашаа болон барилга барихад кадастрын эргэлтийн цэгүүдийг тогтоох, хяналт тавьж ажиллах. | Бичиг хэргийн зардал: 50.000 төгрөг | “Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт тавьж ажиллах. | Жил бүр тогтмол хийгддэг ажил. | Газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын кадастрын эргэлтийн цэгүүдийг тогтооно. | Тайлант хугацаанд “Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшигч, ашиглагч нийт 10 аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тухайн эдэлбэр газар дээрээ барьсан барилгын суурийн цэгүүдийг мэргэжлийн байгууллагаар хэмжсэн хэмжилтийн координатын дагуу газрын нэгдсэн мэдээллийн санд оруулж, мэдээллийг шинэчлэн, шаардлагатай материалыг холбогдох аж ахуй нэгжүүдэд хүргүүлэн ажилласан. | 100 |
| 4.18 | Бүсийн хашаанд тарьсан ногоон байгууламж болох мод, бут, зүлэг, таримал ургамал зэргийн арчилгааг хийх, цаг тухай бүрт гарсан тохижилт үйлчилгээний ажлыг зохион байгуулах. | - | Бүсийн ногоон байгууламжийн тоо, хэмжээ. | Тохижилт үйлчилгээний байнга хийгддэг ажил. 15 ширхэг үрийн нүдний суулгац 10 ширхэг агч мод суулган арчилгаа үйлчилгээ хийсэн. | Бүсийн ногоон байгууламжийн 1320 м2 газарт 250 ширхэг модыг тарьж арчилгааг тогтмол хийх, тохижилт үйлчилгээний ажил хийгдэнэ. | Чөлөөт бүс дотор 6,2 га талбай болон нийт бүсийн талбайг 2023.1-9 саруудад 7 хоног тутам аж ахуйн нэгжүүдийн нийт ажилтан болон бүсийн албан хаагчид хамтран цэвэрлэгээ хийж, ААН-үүдийн дэлгүүрийн байр, ЗАА-ны оффист ариутгал, бүсийн дотор болон гадна нийтийн бие засах газрыг цэвэрлэн ариутгал хийлгэх ажлыг зохион байгуулж ажилласан. Бүсийн доторх хогийн цэгийн шатсан үнсийг 7 удаа сумын хогны машинаар гадагш тээвэрлүүлж хаях ажлыг зохион байгуулсан.<br>2023 онд бүсийн хашааны гадна хэсгийг улирал болгон цэвэрлэж 4 машин хог сумын хогийн цэг рүү зөөвөрлөн хаясан.<br>Оффиссын байрны өдөр тутмын усны хэрэглээг албан хаагчдын хувийн машинаар 7 хоногт 4-5 удаа 1тн-н саваар зөөвөрлөдөг бөгөөд давхар нөөц усны тавин ЗАА-ны байрны усны хэрэгцээг ханган ажиллаж байна,<br>ЗАА болон аж ахуйн нэгжтэй хамтран 6,2 га талбай дээр тарьсан мод ургамлыг өдөр тутам услах арчлах ажлуудыг зохион байгуулж нийт тарьсан модны 70% нь ургаж байна. Оффиссын урьд талбайд тарьсан ногоон байгууламж болох мод бут зэргийг арчилгаа хийж цэвэрлэгээнээс гарсан цасаар овоолго хийж орчин тойрны хог хаягдлыг байнга цэвэрлэж, орчны бут сөөг зэрлэг ургамлыг хадах зэргээр тохижилт үйлчилгээний ажлыг ханган ажиллаж байна. | 96 |

*Төлөвлөгөөг хянасан:* **Төсвийн Ерөнхийлөн захирагч**

....................... ......................... /................................./

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг* *(огноо)*

..............................

*Төлөвлөгөө тайлагнасан:* **Төсвийн Шууд захирагч**

............................. ......................... /................................./

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг* *(огноо)*

.........................